НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

*Дотоод албан хэрэгцээнд*



# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Эпидемиологийн **04** дугаар долоо хоног

## Нэг. Угаарын хийн хордлогын шалтгаант үйл явдлын мэдээ

Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар **362** иргэн угаарын хийн хордлогод өртсөн байна. Үүнээс:

| 308 | 45 | 9 |
|---|---|---|
| • Эмнэлгийн тусламж авч буцсан | • Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан | • Нас барсан |

**Мэдээ ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагаар:**




**Хүн ам зүйн байдал:**

- **52%** Эмэгтэй /190/
- **48%** Эрэгтэй /172/
- **59%** Насанд хүрэгч /215/
- **41%** Хүүхэд (0-17) нас /147/

**Угаарын хийн хордлогод өртсөн нийт иргэдийг байршлаар ялган авч үзвэл:**

**Улаанбаатар хот – 339**

- Байршлаар авч үзвэл БЗД, СХД, ХУД-т зонхилон бүртгэгдсэн байна.




*Зураг 1. Угаарын хийн хордлогын тохиолдол, дүүргээр*

**Хөдөө орон нутаг - 23**

*Хүснэгт 1. Угаарын хийн хордлогын тохиолдол, аймгаар*

| **Хөдөө орон нутаг:** | | **Сум/Хүний тоо** |
|---|---|---|
| | | **5/23** |
| Аймгаар: | Баянөлгий аймаг | 2/15 |
| | Сэлэнгэ аймаг | 1/5 |
| | Өвөрхангай аймаг | 1/1 |
| | Төв аймаг | 1/2 |

## ЭПИДЕМИОЛОГИЙН 04-Р ДОЛОО ХОНОГТ:

- 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 1 дүгээр сарын 25-ны өдрийн буюу 4 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын 101 тохиолдол, 6 нас баралт бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 47%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 44%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




*Зураг 2. Угаарын хийн хордлогын тохиолдол, долоо хоногоор*

## Хоёр. Химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 56 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Үүнээс:

| 29 | 27 | 0 |
|---|---|---|
| • Эмнэлгийн тусламж авч буцсан | • Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан | • Нас барсан |

**Хүн ам зүйн байдал:**

**52%** Эмэгтэй /29/

**48%** Эрэгтэй /27/

**77%** Насанд хүрэгч /43/

**23%** Хүүхэд (0-17нас) /13/

### ЭПИДЕМИОЛОГИЙН 04-Р ДОЛОО ХОНОГТ:

- 2025 оны 04 дугаар долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн 19 хүн хандаж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үетэй ижил байгаа болов ч сүүлийн 5 жилийн дунджаас 64%-иар өссөн байна.




*Зураг 3. Химийн цочмог хордлогын тохиолдол, долоо хоногоор*

*Хүснэгт 2. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (ХЯТҮТ, ЭХЭМҮТ)*

| № | Шалтгаан | Санаатай | Санамсаргүй | Нийт |
|---|---|---|---|---|
| **1** | Химийн бодисын хордлого | 9 | 20 | 29 |
| **2** | Эмийн хордлого | 21 | 6 | 27 |
| **Нийт** | | 30 | 26 | 56 |

- Санаатай буюу амиа хорлох зорилгоор эм, химийн бодис ууж, хордлогод өртсөн 30 тохиолдол бүртгэгдсэн ба 14-өөс 82 насныхан байна.
- Санамсаргүй хордлогын тохиолдлын 46%-ийг 0-17 насны хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай бүтээгдэхүүнд өртсөн байна.

*Дотоод албан хэрэгцээнд*

**ХОР СУДЛАЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА**